



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 15 (396)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай*
- *Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Төрийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах тухай*
- *Хөтөлбөр батлах тухай  
(Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр)*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны дөрөвдүгээр сарын 21

№15 (39)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

663.	Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 52	342
664.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 53	342
665.	Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Дугаар 54	342
666.	Хас-Очирын Батдоржид Монгол Улсын гавъяат тээвэрчин цол хүртээх тухай	Дугаар 55	343
667.	Рословын Бат-Эрдэнэд Монгол Улсын гавъяат нисгэгч цол хүртээх тухай	Дугаар 56	344
668.	Пэлжээгийн Онхуудайд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай	Дугаар 57	343
669.	Цүрэмийн Мухарт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 58	343
670.	Бадамдоржийн Ганбатад Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 59	344
671.	Нямжавын Дугарсүрэнд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 60	344
672.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 61	344

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

673.	Үндэсний хорооны тухай	Дугаар 25	348
674.	Төрийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах тухай	Дугаар 61	349
675.	Хамтарсан комиссын Монголын хэсгийг татан буулгах тухай	Дугаар 62	350
676.	Шүүхийн шинжилгээний үндэсний төв байгуулах тухай	Дугаар 63	350
677.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 64	351

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

### Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 5-д заасныг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөрөө хүсэлт гаргасан Дүндэвийн Цаянг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, өөр ажил, албан тушаалд томилогдох болсон Хишгээгийн Байгалмааг Говьсүмбэр аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан Ширэндэвийн Бат-Эрдэнийг Хөвсгөл аймгийн

шүүхийн ерөнхий шүүгчийн, ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй тухай Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан тул Дашдаваагийн Энхбаярыг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Гуудайн Гандмааг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

### Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хишгээгийн Байгалмааг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчийн, Жамсранжавын Эрдэнэчимэгийг Төв аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Баасанжавын Зориг,

Дамдинжавын Солонго нарыг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн, Могнооны Болормааг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн, Гомбосүрэнгийн Буяннэмэхийг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

### Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1."Монгол Улсын Төрийн шагналын тухай дүрэм"-ийн хоёрын 7 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"7.Монгол Улсын Ерөнхийлөгч тодорхой бүтээлийг нэр цохон Төрийн шагналд дэвшүүлж, бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргаж болно. Ийм бүтээлд холбогдох баримт бичгийг дүрэмд заасны дагуу бүрдүүлэх ба шаардлагатай бол өсгөж тодруулах болон хянан магадлагаа хийх

шинжээчийн ажлын хэсгийн санал дүгнэлт авч болно."

2."Монгол Улсын Төрийн шагналын тухай дүрэм"-ийн дөрөвийн 3 дахь заалтад дараах нэмэлт оруулсугай.

"3.Шаардлагатай тохиолдолд Төрийн шагналыг гардуулах ёслолын хугацааг Ерөнхийлөгч өөрчлөн тогтоож болно."

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.БАГАБАНДИ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

**Хас-Очирын Батдоржид Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай**

Автотээврийн байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж улсын чухал хариуцлагатай үүрэг даалгавар, цаг үеийн ажлыг биелүүлэхэд хамт олноо хошуучлан оролцон хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж байсныг нь үнэлж Нийслэлийн худалдаа үйлчилгээний "Алтай

сайхан" ХХК-ийн ерөнхий зөвлөх, ахмад тээвэрчин Хас-Очирын Батдоржид Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

**Рословын Бат-Эрдэнэд Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээх тухай**

Иргэний агаарын тээврийн салбарт санаачилга, үр бүтээлтэй ажиллаж орчин үеийн нисэх онгоц жолоодох арга барилыг чадамгай эзэмшин, нислэгийн аюулгүй байдлыг хангах, нисгэгчдийг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "МИАТ" ХК-ийн А-310

онгоцны дарга, багш нисгэгч Рословын Бат-Эрдэнэд Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

**Пэлжээгийн Онхуудайд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж Монгол улсад цөмийн анагаах ухааныг үүсгэн, улмаар хөгжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын клиникийн төв эмнэлгийн цөмийн онош зүйн тасгийн

эрхлэгч Пэлжээгийн Онхуудайд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

**Цүрэмийн Мухарт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн төв, орон нутгийн болон шинжлэх ухааны байгууллагуудад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж эрдэм судлалын бүтээлүүд туурвиж, залуу эмч нарыг сургаж, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Анагаах ухааны үндэсний хүрээлэнгийн дэд захирал

Цүрэмийн Мухарт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

**Бадамдоржийн Ганбатад Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Урлагийн байгууллагад хөгжимчнөөс удирдаач хүртэл олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж үе үеийнхний таашаалд нийцсэн джаз найрал хөгжмийн бүтээлүүдийг чадварлаг хөгжимдөж, удирдаж, туурвиж, чуулгынхаа урын санг баяжуулах, монголын эстрадын урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын филармонийн "Баян монгол" джаз найрал хөгжмийн удирдаач Бадамдоржийн

Ганбатад Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

**Нямжавын Дугарсүрэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Соёлын байгууллагуудад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж монголчуудын түүхэн өвөг дээдэс – их хаад, эзэн богдуудын түүх шаштирыг судлах, уншигч олонд сурталчлан дэлгэрүүлэх, түүх соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах, хамгаалах үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Хаадын сан" төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Нямжавын

Дугарсүрэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, барилга, боловсрол, соёл урлаг, хэвлэл, мэдээлэл, эрүүл мэнд, статистик, татвар, шүүх, прокурор,

аудит, төрийн болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Сэрээтэрийн Баттөмөр- Улсын ерөнхий прокурорын туслах, Хэрэг эрхлэх газрын дарга

3. Дамбын Сэржээ - ЭМШУИС-ийн зүрх судасны тэнхмийн багш

2. Лувсанвандангийн Манлажав-Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн тэнхмийн эрхлэгч

4. Аюурын Шагдар- "Ариусахуй Бясалгахуй" сонины орчуулагч редактор, ахмад сэтгүүлч

## "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Пүрэвчоймболын Адилбиш- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Одос Намнан" ХХК-ийн захирал
2. Цэрэнжавын Алтанцэцэг - "Отгонтэнгэр" их сургуулийн эрх зүйн тэнхмийн эрхлэгч
3. Түмэнжаргалын Балжинням- Монгол-Оросын хамтарсан "Эрдэнэт" үйлдвэр, "Монголросцветмет" нэгдлийн зөвлөлийн төлөөлөгч, ахлах эдийн засагч
4. Ноосонхүүгийн Батначин- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын хяналтын прокурор
5. Хавдены Бекен- Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
6. Шаравын Бямбаа- ШУТИС-ийн Механик инженерийн сургуулийн багш
7. Лочингийн Ганбаатар- УБТЗ-ын Улаанбаатар зүтгүүрийн делогоийн татах хэсгийн ахлах инженер
8. Гомбосүрэнгийн Ганзориг- АНУ-ын Вашингтон хотын Хуулийн их сургуулийн докторант
9. Шаравын Гочоосүрэн - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 10 жилийн 5 дугаар сургуулийн монгол хэл уран зохиолын багш
10. Цэрэнпилийн Даваасүрэн- БСШУЯ-ны санхүү, эдийн засгийн газрын дарга
11. Пунцагийн Дамчаабазар- Ховд аймгийн Дарви сумын Засаг даргын Тамгын газарт байгаль орчны хяналтын улсын байцаагч
12. Жадамбаагийн Дашдорж- Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн
13. Сандагийн Дүгэр- Нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн "Талх чихэр" ХК-ийн дотоод хяналт шалгалтын байцаагч
14. Тазнаагийн Занашир- Монголын Боксын зөвлөлийн ерөнхийлөгч
15. Самдангийн Зоригтбаатар- Дорноговь аймгийн Сайншанд сумын өндөр настан, түүх соёлын дурсгалт зүйлсийг сэргээн засварлагч
16. Самдангийн Лхагваа - Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх иргэний бүртгэл мэдээллийн албаны дарга
17. Долгорсүрэнгийн Лхагвасүрэн- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Далай ван" цогцолбор сургуулийн ажилтан
18. Халзангийн Лхасүрэн- Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолборын 1 дүгээр сургуулийн математикийн багш
19. Бэхтэйгийн Монголхүү- Монголын зохиолчдын эвлэлийн ахмад ажилтан, зохиолч, орчуулагч, яруу найрагч
20. Буяндэлгэрийн Мэдраа- Дорнод аймгийн Хэрлэн сумын 8 жилийн сургуулийн сургалтын менежер
21. Гэндэнгийн Мягмар- Үндэсний татварын ерөнхий газрын татварын улсын ахлах байцаагч
22. Лхамсүрэнгийн Мягмарсүрэн-Нийслэлийн Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны зохион байгуулагч
23. Зандирын Намжил- Оюуны өмчийн газрын шинжээч
24. Анардын Нансалмаа- Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн эмчилгээний чанарын менежер
25. Бадарчийн Нямаа- ТЗУААЭГ-ын харьяа Амралт үйлчилгээний цогцолборын дарга
26. Гэндэнгийн Одгэрэл- Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрхэт трейд" ХХК-ийн ерөнхий захирал
27. Лхамжавын Онхдой- Монгол- Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн засвар механикийн заводын эдийн засагч
28. Батхүүгийн Отгон- Нийслэлийн Багануур дүүргийн Хүүхэд хөгжлийн төвийн циркийн дугуйлангийн багш

29. Батсүхийн Очирхуяг- Хэнтий аймгийн Аудитын газрын ерөнхий аудиторч

30. Хинаатын Салахият- Баян-Өлгий аймаг дахь худалдаа, үйлчилгээний "Кайнар" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч

31. Баттөмөрийн Солонго- Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын төгөлдөр хуурч

32. Цэвэгмидийн Сумъяа- Өмнөговь аймгийн Шүүхийн ерөнхий шүүгч

33. Чулууны Сүхбаатар- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны Засаг дарга

34. Сосорын Төгсжаргал- Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын оркестрант

35. Очирбатын Хайдав - Сэлэнгэ аймгийн Сант сум дахь Мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн дэд захирал

36. Жамбалын Халзанбанди- Нийслэлийн "ХАК кредит" банк бус санхүүгийн байгууллагын ерөнхий захирал

37. Паньджунайгийн Халиун- Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд

38. Гунгаагийн Цэдэнбалжир- Үндэсний Аудитын газрын ахлах аудиторч

39. Содномын Цэдэндорж- ШУТИС-ийн Уул уурхайн инженерийн сургуулийн тэнхмийн эрхлэгч

40. Дамдины Цэвэрэгээн- Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Орос судлалын тэнхмийн эрхлэгч

41. Пүрэвийн Цэцэгэ- Улсын Дээд Шүүхийн шүүгч

42. Лосолын Чулуунбаатар- Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэлийн "Мон-Со" ХХК-ийн ерөнхий захирал

43. Цэдэвийн Шүнгээ- Нийслэлийн Баянгол дүүргийн өндөр настан, мал эмнэлгийн байгууллагын ахмад ажилтан

44. Рэнцэндоржийн Энхтуяа- Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ-т албан бус боловсролын арга зүйч

45. Өлзийцоогийн Энэбиш- Дорноговь аймгийн Сайншанд сумын 10 жилийн 2 дугаар сургуулийн түүхийн багш

46. Жамъянгийн Эрдэнэбаатар- Нийслэлийн Прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Пунцагийн Алимаа- Оюуны өмчийн газрын мэргэжилтэн, шинжээч

2. Булчингийн Батноров- Олон улсын хүүхдийн "Найрамдал" төвийн хоолны технологич

3. Цэвээний Бат-Өлзий- Дархан-Уул аймаг дахь "Дархан нэхий" ХК-ийн оёдлын үйлдвэрийн токарьчин

4. Даактын Баттулга- Увс аймгийн Аудитын газрын ерөнхий аудиторч

5. Цогтын Бат-Эрдэнэ- Нийслэлийн Багахангай дүүрэг дэх барилга, үйлдвэрлэл, үйлчилгээний "Ганьт" ХХК-ийн захирал

6. Халзангийн Баярсайхан- Дархан-Уул аймаг дахь Төмөрлөгийн үйлдвэрийн бэлдэц цехийн технологич инженер

7. Төмөрийн Баясгалан- Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр Шүүхийн шүүгч

8. Нүүдлээгийн Бурмаа- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 жилийн 32 дугаар сургуулийн бага ангийн багш

9. Гэндэнгийн Будтуяа- Дорнод аймгийн Хэрлэн сумын "Хан-Уул" цогцолбор сургуулийн захирал

10. Дуламсүрэнгийн Бэхбат- Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 83 дугаар сургуулийн бага ангийн багш

11. Дондогийн Ганбилэг - Үндэсний Аудитын газрын тэргүүлэх аудитор бөгөөд нэгдүгээр хэлтсийн дарга

12. Гүрдоржийн Гантуяа - Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын хөгжимчин

13. Дамдинсүрэнгийн Гантуяа - Дорнод аймгийн Хүүхдийн төлөө төвийн арга зүйч

14. Содовжамцын Гансүх - Үндэсний Аудитын газрын ахлах аудиторч

15. Бадарчийн Гүйлээ - Монголын Ахмадын холбооны удирдах зөвлөлийн ахлах нягтлан бодогч

16. Пүрэвийн Дагвадорж - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн 2 дугаар амбулаторийн эрхлэгч

17. Нямын Дамдинсүрэн- Өмнөговь аймгийн Шүүхийн Тамгын хэлтсийн нягтлан бодогч

18. Сүхбаатарын Дандар- Монгол- Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий эмч

19. Дэлэгийн Дулмаа- Дундговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга

20. Ванчигдоогийн Жавхлан- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Шүүхийн шүүгч

21. Дадалын Завуд - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Шүүхийн шүүгч

22. Аргамжийн Мандах- Төв аймгийн Сэргэлэн сумын нийгмийн даатгалын байцаагч

23. Эрдэнэбаярын Мягмардорж-Оюуны өмчийн газрын эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

24. Аюжмын Наранцэцэг- Оюуны өмчийн газрын мэргэжилтэн

25. Мянгаагийн Наранцэцэг- Сэлэнгэ аймгийн Шүүхийн шүүгч

26. Шаравын Нүрээ- Нийслэлийн ажилчин залуучуудын ээлжийн сургуулийн газарзүйн багш

27. Шүхэртийн Нэргүй- Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 84 дүгээр сургуулийн бага ангийн багш

28. Гэлэнхүүгийн Оюун- Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тэргүүлэх зэргийн их эмч

29. Дөрвөлжингийн Оюунцэцэг- "Бо интернэшнл" ХХК-ийн харьяа англи хэлний "Хобби ерөнхий боловсролын сургуулийн захирал

30. Дэмбэрэлийн Оюунчимэг- Дархан-Уул аймаг дахь сум дундын Шүүхийн шүүгч

31. Лхагвасүрэнгийн Сайнтуяа- Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл, барилга угсралт, засварын "Эм Би Си Эйч" ХХК-ийн захирал

32. Дамдинсүрэнгийн Саранцэцэг- ШУТИС ийн Гадаад хэлний сургуулийн Орос, Монгол судлалын тэнхмийн багш

33. Нанзадын Сосор - Нийслэлийн Налайв дүүрэг дэх Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн инженер багш

34. Дагдоржийн Темербаатар - Нийслэлийн хөнгөн үйлдвэрийн "Нэхээсгүй эдлэл" ХК-ийн засварчин

35. Уржинбадамын Түмэнжаргал- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Шүүхийн шүүгч

36. Пагамын Уртнасан- ТЗУААЭГ-ын харьяа Амралт үйлчилгээний цогцолборын тогооч

37. Долгорсүрэнгийн Цанжид- Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий захиргааны эдийн засгийн хэлтсийн эдийн засагч

38. Довчингийн Цогтбаатар- Говь-Алтай аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн захирал

39. Балдангийн Энхжаргал- БСШУЯ-ны дэд сайдын туслах

40. Даваагийн Эрдэнэчулуун - Оюуны өмчийн газрын мэргэжилтэн

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н. БАГАБАНДИ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 2 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

### Үндэсний хорооны тухай

Жендерийн тэгш байдлыг хангах талаар дэвшүүлсэн Мянганы хөгжлийн зорилт, Жендерийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтын 32 дахь заалтыг дараахь байдлаар өөрчилсүгэй:

32.	Жендерийн тэгш байдлын Үндэсний хороо	Монгол Улсын Ерөнхий сайд
-----	---------------------------------------	---------------------------

2. Жендерийн тэгш байдлын Үндэсний хорооны дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2001 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 22 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Жендерийн тэгш байдлын Үндэсний хорооны ажлын албыг байгуулж холбогдох зардлыг төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайханд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** Ц.ЭЛБЭГДОРЖ

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Үндэсний зөвлөл байгуулах тухай" Засгийн газрын

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД** Ц.БАЯРСАЙХАН

*Засгийн газрын 2005 оны 25 дугаар тогтоолын хавсралт*

### ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Хорооны бүтэц, зохион байгуулалт

1.1. Жендерийн тэгш байдлын Үндэсний хороо /цаашид хороо гэх/ нь жендерийн тэгш байдлыг хангах асуудлаархи үндэсний хэмжээний орон тооны бус зөвлөлдөх байгууллага мөн.

2.1. Хорооны бүрэлдэхүүн нь төрийн байгууллага, иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллөөс бүрдэнэ.

1.2. Хорооны үндсэн зорилго нь жендерийн тэгш байдлыг хангах асуудлаар бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Жендерийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс гаргасан үүсгэл санаачилгыг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад оршино.

2.2. Хорооны бүрэлдэхүүнийг Үндэсний хорооны дарга батална.

1.3. Хороо нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

2.3. Хороо нь шаардлагатай бол дэд хороо, тодорхой асуудлаар зөвлөл, ажлын хэсэг болон жендерийн шинжээчдийн бүлэг байгуулан ажиллуулж болно. Тэдгээрийн ажиллах журмыг хороо батална.

1.4. Хороо нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.4. Хорооны дарга нь Ерөнхий сайд, дэд дарга нь хүн ам зүйн бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

1.5. Хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд хэлбсгдох байгууллага түүнийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

2.5. Хорооны өдөр тутмын ажлыг Үндэсний хорооны ажлын алба (цаашид "Ажлын алба" гэх) хариуцан гүйцэтгэх бөгөөд хорооны нарийн бичгийн даргын үүргийг ажлын албаны дарга гүйцэтгэнэ.

2.6. Ажлын албаны даргыг Хорооны даргатай зөвшилцөн Нийгмийн хамгаалал,

хөдөлмөрийн сайд томилно.

2.7. Хороо хагас жил тутам хуралдана. Шаардлагатай бол хорооны дарга ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

2.8. Хороо нь ажлаа хагас, бүтэн жилээр төлөвлөнө.

2.9. Хороо нь ажлаа жил бүр Засгийн газарт тайлагнана.

Гурав. Хорооны эрх, үүрэг

3.1. Хороо нь дараахь эрхтэй байна:

3.1.1. аймаг, нийслэлийн салбар хороо, ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөмж, чиглэл өгөх;

3.1.2. жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр зарцуулж байгаа хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;

3.1.3. аймаг, нийслэлийн салбар хорооны тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх.

3.2. Хороо нь дараахь үүрэгтэй байна:

3.2.1. жендерийн тэгш байдлыг хангах асуудлын хүрээг тодорхойлж, жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг холбогдох байгууллагад уламжлах;

3.2.2. жендерийн тэгш байдлын асуудлаархи хууль тогтоомж, энэ чиглэлээр тус улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийн талаар зөвлөмж гаргаж, Засгийн газар, холбогдох байгууллагад санал оруулах;

3.2.3. жендерийн асуудлыг үндэсний хэмжээний хөтөлбөр, төсөл, салбарын

бодлого, төлөвлөлтөд тусгах чиглэлээр санал гаргах;

3.2.4. жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр зарцуулж байгаа хөрөнгийн үү ашгийг нэмэгдүүлэх талаар санал гаргаж холбогдо: байгууллага, албан тушаалтанд хандах;

3.2.5. аймаг, нийслэлийн салбар хороодын үйл ажиллагааны уялдаа холбоо хангахад дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Үндэсний хорооны санхүүжилт

4.1. Хороо нь дараахь эх үүсвэрээс санхүүжинэ:

а/хөтөлбөр, төслийн санхүүжилт, ханди тусламж;

б/бусад.

Тав. Орон нутгийн салбар хороо

5.1. Үндэсний хороо нь орон нутагт салбар хороотой байна.

5.2. Салбар хороог аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд ажиллуулна.

5.3. Салбар хороо нь Үндэсний хорооноос гаргасан зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, биелэлтэд хяналт тавина.

5.4. Салбар хорооны бүрэлдэхүүн, дүрмийг тухайн шатны Засаг дарга батална.

5.5. Салбар хороо нь ажлаа Үндэсний хороо болон тухайн шатны Засаг даргад тайлагнана.

5.6. Салбар хороо нь ажлын тайлангаа хагас жил тутам Үндэсний хороонд ирүүлж байна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 3 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

### Төрийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Эрчим хүчний сургалтын төв" төрийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгаж тус үйлдвэрийн дансанд бүртгэлтэй үндсэн болон эргэлтийн хөрөнгийг зохих журмын дагуу Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төвд шилжүүлэх арга хэмжээ

авахыг Түлш, эрчим хүчний сайд Т.Очирхүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД  
БӨГӨӨД ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ  
САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

С.БАТБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 3 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

*Хамтарсан комиссын Монголын хэсгийг татан буулгах тухай*

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 94 дүгээр тогтоол бүрэн хэрэгжсэн тул Монгол-Хятадын улсын хилийн шугамыг хоёр дахь удаа шалгах Хамтарсан комиссын Монголын хэсгийг

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН  
САЙДЫН ҮҮРЭГ**  
**ГҮЙЦЭТГЭГЧ** **Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 3 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

*Шүүхийн шинжилгээний үндэсний төв байгуулах тухай*

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалт, Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн 44 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

4. Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж мөрдүүлэн Шүүх-нягтлан бодох бүртгэлийн магадалгаа хийх дүрмийг шинэчлэн боловсруулж 2005 оны 6 дугаар сарын 1-ний дотор Засгийн газарт оруулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

1. Эрүүл мэндийн яамны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх-нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэнг нэгтгэж Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний төв байгуулсугай.

5. Шүүхийн шинжилгээний үндэсний төвийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тэдний мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх ажилд байнгын дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Н.Алтанхуяг, Эрүүл мэндийн сайд Т.Ганди, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нэрт үүрэг болгосугай.

2. Аймгийн нэгдсэн эмнэлгийн шүүх-шинжээч эмч, Засаг даргын дэргэдэх шүүх-нягтлан бодох бүртгэлийн магадалгаа хийх орон тооны бус комисс, Цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн лабораторийн шинжээч нарыг нэгдсэн удирдлагаар хангаж мэргэжил, арга зүйн байнгын туслалцаа үзүүлж ажиллахыг Шүүхийн шинжилгээний үндэсний төвд үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Шүүх-нягтлан бодох бүртгэлийн магадлах албаны тухай" Засгийн газрын 1993 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 9 дүгээр тогтоол, "Цагдаагийн-ерөнхий газрын бүтэц, орон тоог батлах тухай" Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 189 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн "ж" заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Шинжилгээний байгууллагуудыг нэгтгэсэнтэй холбогдуулан дээрх байгууллагуудын эзэмшиж, ашиглаж байгаа үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг балансаас балансад орон тоо, төсвийн хамт Шүүхийн шинжилгээний үндэсний төвд энэ оны 4 дүгээр сард багтаан шилжүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд Н.Алтанхуяг, Эрүүл мэндийн сайд Т.Ганди, Төрийн өмчийн хороо (З.ЭНХБОЛД)-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД** **Ц.НЯМДОРЖ**

**САНГИЙН САЙД** **Н.АЛТАНХУЯГ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД** **Т.ГАНДИ**

2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

**Хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын урьдчилсан төсвийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Сангийн сайд Н.Алтанхуяг, Үйлдвэр, худалдааны сайд С.Батболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Үйлдвэр, худалдааны сайд С.Батболдод тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1999 онь 2 дугаар сарын 1-ний өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**
**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД**
**С.БАТБОЛД**
**Засгийн газрын 2005 оны 64 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт**
**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ  
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Жижиг, дунд үйлдвэрийн өнөөгийн байдал, үндэслэл

2004 оны дүнгээр манай улсад нийт 25356 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн дотор 50 хүртэл ажиллагсадтай аж ахуйн нэгж 96.0 хувийг эзэлж байна. Эдгээр жижиг, дунд аж ахуйн нэгжүүд улсын төсвийн 1.8 хувийг бүрдүүлж, 300 мянга гаруй хүнийг ажлын байраар хангаж байна. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүд нь техник, технологийн шинэчлэл хийх, ажил, үйлчилгээгээ өргөтгөх санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн төслийг хот, орон нутагт хэлэлцүүлэх явцад манай улсад ядуурал, ажилгүйдэл дорвитой буурахгүй байгаагийн нэг шалтгаан нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид, түүнчлэн албан бус секторт хувиараа хөдөлмөр эрхлэж буй хүмүүсийг төрөөс санхүүгийн тодорхой бодлогоор дэмжихгүй байгаатай холбоотой гэсэн санааг хэлэлцүүлэгт оролцогчид илэрхийлж байлаа.

Иймд жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, татвар, санхүүгийн бодлогоор дэмжих, тэдэнд үзүүлж байгаа үйлчилгээг түргэн шуурхай, хүнд суртлын дарамтгүй болгох, тус үйлдвэрлэлд ажиллагсдын мэдлэг, ур чадварыг сайжруулах, зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг авах шаардлага урган гарч байна. Энэ зорилгоор жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг шинэчлэн боловсруулав.

Хоёр. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн зорилго, зорилт

**2.1. Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, албан бус бизнес эрхлэгчдийг албан ёсны жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, нэмэгдүүлэхэд оршино.

**2.2. Хөтөлбөрийн зорилт**

Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтуудаар хэрэгжүүлнэ:

2.2.1. жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх;

2.2.2. төрийн захиргааны байгууллагаас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгох;

2.2.3. жижиг, дунд үйлдвэрийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжих;

2.2.4. жижиг, дунд үйлдвэрлэлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалт явуулах, мэдээллээр хангах, зөвлөлгөө өгөх, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. "Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх" зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах;

3.1.2. жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор татварын болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох хуулийн төсөл боловсруулж батлуулах;

3.1.3. жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тэргүүлэх чиглэлийг боловсруулж батлуулах;

3.1.4. жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн зээлийн барьцааны чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тогтолцоог бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх;

3.1.5. техник, технологи, машин, тоног төхөөрөмжийг лизингээр олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх.

3.2. "Төрийн захиргааны байгууллагуудаас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгох" зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. лиценз, зөвшөөрөл, бүртгэлийн ажиллагааг хялбаршуулах талаар дсорхи арга хэмжээг хэрэгжүүлнэ;

3.2.1.1. төрийн захиргааны бүх шатны байгууллагаас аливаа бүртгэл, лиценз, зөвшөөрлийг цахим сүлжээгээр олгодог тогтолцоог бүрдүүлэх, хэвшүүлэх;

3.2.1.2. бизнес эрхлэхэд саад тотгор болж буй хууль тогтоомж, бүх шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг хянан үзэж, зарим лиценз, зөвшөөрөл, журам, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ бүхий дүрэм болон хураамжийг хүчингүй болгох;

3.2.1.3. бүх шатны Засаг дарга, Тамгын газраас гаргасан үйлдвэрлэл, үйлчилгээг журамласан шийдвэрийг хянан үзэж, хууль тогтоомжид нийцүүлэх;

3.2.1.4. үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн нэгжийн тоог олшруулах, бүртгэлийг хөнгөвчлөх, хураамжийг үйлчилгээний өөрийн өртөгтэй нь нийцүүлэн тогтоож мөрдөх.

3.2.2. хяналт, шалгалтын тогтолцоог хялбаршуулах талаар доорхи арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.2.2.1. нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах объектод тогтоосон заавал мөрдөх стандартаас бусад стандартыг аль болох зөвлөмжийн шинж чанартай болгож цөөрүүлэх;

3.2.2.2. улс, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд хяналт, шалгалтын давхардлыг арилгах, хяналт шалгалтыг бизнес эрхлэгчдэд зөвлөлгөө өгөх, мэдээллээр хангахад чиглүүлэх;

3.2.2.3. улсын байцаагчийн дүгнэлтийг бүх шатанд хүлээн зөвшөөрөх журамд шилжих замаар хяналт шалгалтын тоог цөөрүүлэх;

3.2.2.4. хувийн өмчийн халдашгүй дархан байдлыг хангах үүднээс шуурхай шалгалт хийх онцгой нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд улсын мэргэжлийн хяналтын байгууллагын зүгээс хувийн өмчид хяналт шалгалт хийхдээ байгууллагын удирдлага буюу өмчийн эзэнээс бичгээр зөвшөөрөл

авсны үндсэн дээр гүйцэтгэх эрх зүйн үндсийг бий болгох.

3.2.3. жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хүрээнд хувийн хэвшил, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг нэмэгдүүлэх талаар доорхи арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.2.3.1. бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, хуулиар нууцад хамааруулснаас бусад шийдвэртэй иргэд чөлөөтэй танилцах орчинг бүрдүүлэх;

3.2.3.2. бизнестэй холбоотой аливаа шийдвэрийн төслийг боловсруулах, хэлэлцэхдээ олон нийтийн саналыг урьдчилан авдаг журмыг хэвшүүлэх;

3.2.3.3. мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөл байгуулж, шийдвэр боловсруулах явцад оролцуулж байх;

3.2.3.4. төрийн үйлчилгээний талаархи санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах шуурхай цэг ажиллуулах.

3.3. "Жижиг, дунд үйлдвэрийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжих" зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. жижиг, дунд үйлдвэрийг татварын болон нийгмийн даатгалын бодлогоор дэмжих хүрээнд:

3.3.1.1. Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхлэж байгаа жижиг, дунд үйлдвэрийг эхний 3 жилийн хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх;

3.3.1.2. жижиг, дунд үйлдвэрийн зар сурталчилгаа, сургалтын зардал, сайн дурын даатгалын хураамж, хэвийн хорогдол, урсгал засварын зардал зэрэг бизнесийн бодит зардлыг татвар ногдуулах орлогоос хасаж тооцох;

3.3.1.3. жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай импортоор оруулах техник, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлэх;

3.3.1.4. экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг, дунд үйлдвэрийн импортолж байгаа үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн болон туслах материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлэх;

3.3.1.5. ажил олгогчоос авч байгаа нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулах асуудлыг судалж шийдвэрлэх;

3.3.1.6. гаалийн жишиг болон хэлцлийн үнэ бүрдүүлэх нээлттэй механизмыг бий болгоход тарифын зөвлөл, импортлогчдын оролцоог нэмэгдүүлэх.

3.3.2. жижиг, дунд үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжих хүрээнд:

3.3.2.1. жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалт, хөгжлийн сан байгуулж ажиллуулах;

3.3.2.2. жижиг, дунд үйлдвэрт зориулан бага хүүтэй, урт хугацааны арилжааны зээлийн эх үүсвэрийг бий болгох, нэмж олох талаар Сангийн яам, Монгол банк, арилжааны банкуудтай хамтран арга хэмжээ авах;

3.3.2.3. гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр жижиг, дунд үйлдвэрийн төслийг санхүүжүүлэх, төслийн хэрэгжилтэд мэргэжлийн холбоодын зөвлөлөөс хяналт тавих боломжийг бий болгох;

3.3.2.4. улсын болон орон нутгийн төсвийн захиалгаар санхүүжих төсөл, хөтөлбөрийн арга хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийг түлхүү хамруулах бодлого баримтлах.

3.4. "Жижиг, дунд үйлдвэрлэлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалт явуулах, мэдээллээр хангах, зөвлөлгөө өгөх, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох" зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан Бизнес инкубаторуудыг байгуулах;

3.4.2. бүсийн төвүүдэд технологи дамжуулах төв байгуулах, мэргэжлийн боловсон

үчин бэлтгэх, мэдээллээр хангах ажлыг зохион  
айгуулах;

3.4.3. жижиг, дунд үйлдвэрийн удирдлага,  
инженер техникийн ажилтныг их, дээд сургууль,  
оллежид, ажилчдыг мэргэжлийн сургалт,  
үйлдвэрлэлийн төвийг түшиглэн мэргэжил  
дээшлүүлэх, мэргэшил эзэмшүүлэх сургалт зохион  
айгуулах;

3.4.4. төрийн бус байгууллага, зөвлөлгөө  
гэх төв зэрэг жижиг, дунд үйлдвэр дэмжих үүсгэл  
знаачилгын байгууллагын үйл ажиллагаа болон  
омоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд тулгуурлан  
дэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулахыг  
дэмжих.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион  
байгуулалт, санхүүжилт

## 4.1. Удирдлага, зохион байгуулалт

4.1.1. хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын  
эмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт  
гавих үүргийг Үндэсний зөвлөл, Үйлдвэр,  
судалдааны яам хэрэгжүүлнэ. Үндэсний зөвлөл нь  
эрон нутагт салбар зөвлөлтэй байж болно.

4.1.2. Үндэсний зөвлөл нь дор дурдсан  
ажлыг эрхэлнэ:

4.1.2.1. хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан  
зохион байгуулах, хяналт тавих;

4.1.2.2. салбар зөвлөлийг удирдлагаар  
хангах.

4.1.3. Үндэсний зөвлөл нь улирал бүр  
хуралдах бөгөөд шаардлагатай үед Зөвлөлийн  
дарга хуралдааныг зарлан хуралдуулж болно.

4.1.4. Зөвлөлийн үйл ажиллагааг тус  
зөвлөлөөс баталсан дүрмээр зохицуулна.

## 4.2. Хөтөлбөрийн санхүүжилт

4.2.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь  
санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

4.2.1.1. жижиг, дунд үйлдвэрийг дэмжих  
хөрөнгө оруулалт, хөгжлийн сан;

4.2.1.2. улсын болон орон нутгийн төсөв;

4.2.1.3. олон улсын байгууллага,  
хандивлагч орнуудын зээл, тусламж;

4.2.1.4. банкны зээл, хувийн хөрөнгө  
оруулалт;

4.2.1.5. бусад.

4.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе  
шат

Хөтөлбөрийг 2005-2010 онд хэрэгжүүлнэ.

1 дүгээр үе шат: 2005–2006 он

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/жижиг, дунд үйлдвэр хөгжих эрх  
зүйн орчинг бүрдүүлэх, журам, стандарт, техникийн  
нөхцөл зэрэг баримт бичгийг боловсруулах,  
шинэчлэн батлуулах;

б/“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих  
сан”-г шинэчлэн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан” болгон зохион  
байгуулж ажиллуулах;

в/төрийн үйлчилгээний тагаархи  
санал хүсэлт, гомдлыг хүлээн авах “Шуурхай  
үйлчилгээний цэг”-ийг байгуулах;

г/мэргэжлийн холбоодын нэгдсэн  
зөвлөл байгуулж шийдвэр боловсруулах явцад  
санал, зөвлөмж авч байх;

д/үл хөдлөх эд хөрөнгийн  
бүртгэлийн цэгийг хэрэгцээг харгалзаж нэмж  
байгуулах;

е/лиценз, зөвшөөрөл олгох үйл  
ажиллагааг хялбарчлах, цахим сүлжээгээ олгох;

ж/хөрөнгийн асуудал шийдэгдэх  
хэмжээгээр Бизнес инкубатор, Технологи  
дамжуулах төв байгуулах.

2 дугаар үе шат: 2007–2008 он

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/Үе шатанд хэрэгжүүлсэн арга хэмжээг дуусгах;

б/Технологи дамжуулах төвийг хот, суурин газар болон бүсийн төвүүдэд байгуулах;

в/Бизнес инкубаторыг бүсийн төв, хотод байгуулах;

г/Мэргэжлийн сургалтын төвүүдийг бүсийн төвүүд, хот суурин газруудад байгуулах.

3 дугаар үе шат: 2009–2010 он

Энэ үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн үед нь баталж мөрдөнө.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн үр дүн нь жижиг, дунд үйлдвэр хөгжих эрх зүйн орчин бүрдэж, өрсөлдөх чадвартай жижиг, дунд үйлдвэр хөгжиж, тэд зах зээлд өөрийн байр суурийг эзэлж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт болон ажилгүйдэл, ядуурлыг бууруулсан байдлаар хэмжигдэнэ.

Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

6.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын шалгуур үзүүлэлт: шинээр боловсруулж батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль тогтоомж, тэдгээрт жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдээс өгсөн үнэлгээ-санал асуулгын дүнгээр, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн барьцааны тоо хэмжээ, түүний бодит өсөлт, лизингийн үйлчилгээнд хамрагдсан жижиг, дунд үйлдвэр, тоног төхөөрөмжийн тооны өсөлт зэрэг болно.

6.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын шалгуур үзүүлэлт: лиценз, зөвшөөрлийн тоо болон

олголтын хугацааны бууралт, хураамжийн хэмжээ, үйлчилгээний өөрийн өртөгтэй нийцсэн байдлын түвшин, төрийн үйлчилгээний талаархи бизнес эрхлэгчдээс гарсан гомдлын тооны бууралт, хяналт-шалгалтын үр дүн, үр нөлөө, түүний талаархи гомдлын буурайлт, Үйлдвэр, худалдааны яамны веб сайтын мэдээллийн баяжуулалт, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг мэдээлэл, үйлчилгээгээр хангасан байдал, түүний хүртээмж, оновчтой байдлын дээшлэлт, эргэх холбоо, шийдвэр боловсруулахад оролцуулсан төрийн бус байгууллага, иргэдийн тоо, саналыг тусгасан байдлын талаархи тэдгээрийн үнэлгээ зэрэг болно.

6.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын шалгуур үзүүлэлт: жижиг, дунд үйлдвэрийн тоо болон тэдгээрийн үйлдвэрлэл, үйлчилгээний өсөлт, түүний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээний өсөлт, татварын болон ажил олгогчид үзүүлсэн нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээ, жижиг, дунд үйлдвэрийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, арилжааны банкнаас олгосон зээлийн өсөлт, түүний үр дүн, жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ, жижиг, дунд үйлдвэрт олгосон гадаадын зээл, тусламжийн хэмжээний өсөлт, түүний үр дүн, үр нөлөө, шинээр бий болгосон ажлын байрны тооны өсөлт зэрэг болно.

6.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын шалгуур үзүүлэлт: жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөлгөө, үйлчилгээний тоо хэмжээ, түүний үр нөлөө, байгуулсан Бизнес инкубатор, Технологи дамжуулах төвийн тоо, тэдгээрийн үр дүн, үр нөлөө, төрийн бус байгууллага, үүсгэл санаачилгын байгууллага, иргэдийн оролцооны өсөлт зэрэг болно.

6.5. Жижиг, дунд үйлдвэрийн хөтөлбөр хэрэгжүүлэх тухайн жилийн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг Үйлдвэр, худалдааны яам оны эхэнд боловсруулан батлан мөрдөж ажиллана.



## ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРЬДЧИЛСАН ТӨСӨВ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа	Шардагдах хөрөнгийн хэмжээ /сая.төг/
1	Одоо мөрдөж байгаа хууль тогтоомж, шийдвэрийн үр дагаврын шинжилгээ /RIA/-ний талаар судалгаа хийх	ҮХЯ, Гадаадын шинжээчид	2005 оны II улирал	Техникийн туслалцаа
2	Заавал мөрдөх стандарт, зөвлөмжийн стандартыг тогтоох талаар судалгаа хийх	ҮХЯ, СХЗТ	2006	Техникийн туслалцаа
3	Татварын багц хуулинд өөрчлөлт оруулахтай холбогдуулан судалгаа хийх	Гадаад, дотоодын экспертүүд	2005 оны II-III улирал	Техникийн туслалцаа
4	Бизнесийн холбоотой аливаа шийдвэрийн төслийг Засгийн газар хэлэлцэхээс өмнө хэвлэлд нийтлэж, олон нийтийн санал авах журам тогтоох	ХЗДХЯ, ҮХЯ	2005-2008	Техникийн туслалцаа
5	Төрийн үйлчилгээний талаархи санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах "Шуурхай үйлчилгээний цэг" ажиллуулах	Бүх яамд, Нийслэл	2006	250.0
6	Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн нэгжийг нэмэгдүүлэх	ҮХЯ, нийслэл, аймаг, сумд	2005-2006	110.0
7	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх	ҮХЯ, СЯ	2005-2008	15 000.0 /Монгоны сорилтын сан, Японы Засгийн газрын 2 үе шаттай зээл/
8	Бизнес инкубаторуудыг байгуулах		2005-2006	2 000.0
9	Технологи дамжуулах төвүүдийг байгуулах	ҮХЯ, МХХТГ, БСШУЯ	2005-2006	1 000.0
10	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулах	БСШУЯ, ҮХЯ	2005-2008	1 000.0
11	Хөтөлбөр, түүний хэрэгжилт, үйл ажиллагааны талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах	ҮХЯ	2005-2008	50.0
<b>Дүн</b>				<b>19 410.0</b>

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.

"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар- 12,

Төрийн ордон

329612

Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын

Хэвлэх хэсэгт хэвлэв.

329487

Хэвлэлийн хуудас 2